



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/102

Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.5, 32 дугаар зүйлийн 32.1, 32.1.1, 32.1.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрийн 4.3.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сум орон нутгийн гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг тус аймгийн Дэлгэрхаан суманд 2023 оны 2 дугаар сарын 28-аас 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2.Тус сургуульд шаардагдах 4,400,000 (дөрвөн сая дөрвөн зуун мянга) төгрөгийг аймгийн гамшгийн эрсдэлээс хамгаалах сангийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3.Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулах комиссыг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар, удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Дээрх арга хэмжээг тусгай удирдамж төлөвлөгөөний дагуу сахилга хариуцлага, чанарын өндөр түвшинд зохион байгуулж, дүнг танилцуулахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны  
02 дугаар сарын 15-ны өдрийн  
2/102 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

- |                       |              |   |
|-----------------------|--------------|---|
| Комиссын дарга:       | Л.Батсайхан  | Аймгийн Засаг даргын орлогч   |
| Сургуулийн удирдагч:  | Ж.Эрдэнэбат  | Онцгой байдлын газрын дарга, хурандаа   |
| Нарийн бичгийн дарга: | Т.Мөнхжаргал | Онцгой байдлын газрын Ангиллын сургалт, сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг хавсран гүйцэтгэгч, дэслэгч |
| Гишүүд:               | Ц.Гэрэлмаа   | Зооноз өвчин судлалын төвийн дарга  |
|                       | Н.Анхбаяр    | Мал эмнэлгийн газрын дарга  |
|                       | Д.Батхүү     | Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа  |

Аймгийн Засаг даргын 2022 оны  
дугаар сарын 15-ны өдрийн  
02 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Команд штабын сургууль зохион байгуулахад  
шаардагдах зардлын тооцоо

№	Сум	Хугацаа	Шатахууны зардал	Томилолтын зардал	Бусад зардал
1	Дэлгэрхаан сум	2023 оны 2 дугаар сарын 28-аас 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдөр	526,024	3,008,000	865,000
Нийт дүн: 4,400,000					

Аймгийн Засаг даргын 2022 оны  
..... дугаар сарын.....-ны өдрийн  
..... дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

02  
15

Аймгийн Засаг даргын 2022 оны  
..... дугаар сарын.....-ны өдрийн  
..... дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг: Зорилго.

Дэлгэрхаан сумын гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангуулж тохиолдож болзошгүй ой, хээрийн түймэр болон объектын гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах, сумын шуурхай штаб, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулж мэдлэг олгоход чиглэгдэнэ.

Хоёр: Сургалтад хамрагдах сум, зохион байгуулах хугацаа.

Гамшгаас хамгаалах Команд штабын сургуулийг Дэлгэрхаан суманд 2023 оны 2 дугаар сарын 28-аас 2023 оны 3 дугаар сарын 7-ны өдөр хүртэл зохион байгуулна.

Гурав: Зохион байгуулах ажил.

- Сургалт зохион байгуулах байр танхимыг бэлтгэх
- Шуурхай штаб, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг шалгаж аранзны үзлэг хийх
- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн техник хэрэгсэл багаж зэвсэглэмжийг шалгах

- Онцгой комисс, бие бүрэлдэхүүнийг 1 дүгээр цагийн байдал дээр ажиллуулах
- Онцгой комисс, бие бүрэлдэхүүнийг 2 дугаар цагийн байдал дээр ажиллуулах
- Онцгой комисс, бие бүрэлдэхүүнийг 3 дугаар цагийн байдал дээр ажиллуулах
- Өгөгдсөн цагийн байдалтай уялдуулан дадлага, сургууль зохион байгуулах
- Команд штабын сургуулийг дүгнэх, хаах

Дөрөв: Сургуулийн бэлтгэл ажил хангах ажлын хэсэг.

Ажлын хэсгийн

ахлагч:	О.Баярмагнай	Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахмад
Гишүүд:	Ө.Ганзориг	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Хошууч
	Ч.Гантогтох	Эрэн хайх, аврах салбарын дарга,хошууч
	Т.Мөнхжаргал	Ангиллын сургалт, сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг хавсран гүйцэтгэгч, дэслэгч
	Х.Халы	Гал унтраах автомашины жолооч, ахлах ахлагч

Тав: Дүнгийн талаар.

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулсан дүнг илтгэх хуудсаар бичиж аймгийн Засаг дарга, Онцгой комиссын хуралдаанд танилцуулах, цаашид анхаарах зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмж, үүрэг даалгавар өгөх